

Токиогийн Тунхаг

Хорин нэгдүгээр зууны бошгонд эрх чөлөө, ардчилал, хүний эрхийг дээдлэх нь шинэ эрний гол сэдэв болсон байна. Хятадын дотоодод нийгмийн зөрчил эрс хурцдаж, задарч нурахын шатанд хүрсэн байна. Хятадын засгийн газар Өмнөд монгол дэх харгис хэрцгий колоньчлолын дарамтлалаа нэмэгдүүлж өмнөд монголчууд мөхөж сөнөхийн аюулд тулгарлаа. Өмнөд моголчууд бид үндэстний хувь заяанд түүхэн сонголт хийж, шийдвэр гаргах зангилааны цаг мөч хүрч ирлээ.

Энэхүү хүнд хэцүү цаг үед, Өвөр Монголын Ардын Нам онц хурлыг санаачлан хуралдуулсан юм. Америк, Канад, Герман, Швед, Франц, Норвег, Монгол, Өмнөд монгол зэрэг улс орноос зуу шахам намын төлөөлөгч Японы нийслэл Токиод хүрэлцэн ирж, Өмнөд монголын асуудлуудыг авч хэлэлцэв.

Энэ удаагийн хурлаар дараах шийдвэрүүдийг баталсан юм.

1, Өмнөд монголын эрх чөлөө, тусгаар тогтнолыг хүчирхийллийн бус замаар биелүүлэх байр сууриа үргэлжлэн баримтлана.

2, Намын төв байгууллагаа Америкаас Японд шилжүүлэв.

3, Япон, Европ, Америк, Монгол зэрэг улс оронд намын салбаруудыг байгуулав.

4, Намын дүрэм заалт болон бүтцийн байгууламжаа шинэчлэн төгөлдөржүүлэв.

5, Өмнөд Монголын Түр Засгийн газрыг байгуулах бэлтгэл ажлаа эхлүүлнэ. Нөхцөл боломж бүрдсэн үед Өмнөд Монголын Түр Засгийн Газар байгуулана.

Өмнөд монголын хүний эрхийн байдал, үндэстний соёл, экологийн байдалд анхаарлаа хандуулан, үндэстний тусгаар тогтнолын шударга ёсны тэмцлийг дэмжин туслахыг олон орны засгийн газар, олон нийтийн байгууллага жич нийгмийн олон давхаргийн хүмүүст манай нам уриалж байна.

Өмнөд монголын ард түмний улс төрийн эрх ашгийг хүндэтгэн, Өмнөд монгол дэх хүний эрхийн талхидал ноёрхол болон монгол соёл иргэншил, экологийн эвдлэгээ зогсоож, улс төрийн асуудлаас болж хоригдож байгаа Хадаа зэрэг хүмүүсийг даруй түргэн суллахыг нанай нам Хятадын засгийн газарт тулган шаардаж байна.

Дэлхийн монголчууд Монголын тулгар төр үндэслэсний найман зуун жилийн ойг дурсган тэмдэглэхж байгаа энэ үед, Хятадын эзэрхэг засгийн эсрэг

манай намын үйл ажиллагааг туслан дэмжиж, идэвхтэй оролцохыг элэг нэгтэй монголчууддаа уриалж байна.

Эзэн Чингисийн ялагдашгүй эрэмгий зоригийг эрхэмлэн дээдэлж, сүр сүлдээ сэргээж, Өмнөд монголчуудын эрх чөлөө тусгаар тогтнолоо биелүүлсүгэй.

Мөнх хөх тэнгэр ивээх болтугай.

Чингисийн тооллолын 801 он

Манай тооллын 2006 оны 2-р сарын 26-ны өдөр

Өвөр Монголын Ардын Нам Токиод